



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 07

№ 01/11 АУА - 2018/80/СТА-743 Мандалговь хот

**Зөрчил арилгуулах тухай**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар **150,452.00** /Нэг зуун тавин мянга дөрвөн зуун тавин хоёр/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Батлагдсан жишиг хэмжээг мөрдөлгүй нийт 150,452.00 /нэг зуун тавин хоёр мянга дөрвөн зуун тавин хоёр/ төгрөгийн хүнсний материалыг илүү зарцуулсан.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 2 сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар батлагдсан “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ”-г зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зорчсон алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан жишиг хэмжээг баримтлан зарцуулалтыг хийх;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн төсвийн шууд захирагч Ж.Рэнчинсамбуу, нягтлан бодогч Н.Буянжаргал-нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН:**

АУДИТОР

Т.БАТСАЙХАН

ЭРХЛЭГЧ

**ЗӨВШӨӨРСӨН:**  
Дундговь аймаг  
Эрүүл мэндийн төвийн  
Аудитын тухай хуулийн  
28 дугаар зүйлийн  
15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд  
Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд  
Эрүүл мэндийн төвийн төсвийн шууд захирагч Ж.Рэнчинсамбуу  
Нягтлан бодогч Н.Буянжаргал

Ж.РЭНЧИНСАМБУУ

НЯГТЛАН БОДОГЧ

Н.БУЯНЖАРГАЛ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.